

БАТЛАВ
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ч.ӨНӨРБАЯР



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗРЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН САН БҮРДҮҮЛЭХ АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 12 дугаар сарын 22 ны өдөр

№ 317117/2024-01

Байршил	Улаанбаатар хот, Монгол улс
Ажлын нэр	Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Хяналт шалгалтын багийн "Хяналт шалгалтын цахим мэдээллийн сан бүрдүүлэх"
Гэрээний төрөл	Үйлчилгээ
Шаардлагатай хэл	Монгол хэл
Гэрээний хугацаа	2 сар

ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Их Хурлын 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн чуулганы хуралдаанаар батлагдсан "Засгийн газар дахь хяналтын тухай хууль",

Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 474 дүгээр тогтоолоор батлагдсан "Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дүрэм"-ийн 5 дугаар зүйлийн 5.16.5,

Төсвийн Ерөнхийлөн захирагчийн баталсан Худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөний 12 дахь арга хэмжээ,

Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын даргын баталсан 2024 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний 1 дэх хэсэг,

Хяналт шалгалтын багийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.10 дахь арга хэмжээ.

ЗОРИЛГО

Засгийн газар дахь хяналтын тухай хуульд заасны дагуу өргөдөл гомдол шийдвэрлэлтийн явцад хяналт тавих, байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалтын үндэслэл, хяналт шалгалтын үр дүнд илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах, болон эрсдлээс урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, албан шаардлага мэдэгдлийн дэлгэрэнгүй бүртгэл хөтлөх, мэдээллийн санд нэгтгэх, үр дүн өгөгдөл мэдээлэлд дүн шинжилгээ хийх, хууль дүрэмд заасны дагуу Ерөнхий сайд, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, бусад байгууллагад танилцуулах,

шинжилгээ хийх, хууль дүрэмд заасны дагуу Ерөнхий сайд, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, бусад байгууллагад танилцуулах, удирдлагыг бодит мэдээллээр хангах, олон талт тайлан мэдээ гаргах танилцуулга, мэдээллийг хурдан шуурхай бэлтгэх зэрэг Хяналт шалгалтын багийн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай “Мэдээллийн сан”-ийн системийн хөгжүүлэлт хийх, түүхчилсэн дата баазыг бүрдүүлэх чухал ач холбогдолт бүхий систем бий болгоход оршино.

СИСТЕМИЙН ХАМРАХ ХҮРЭЭ

“Цахим мэдээллийн сан” нь Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Хяналт шалгалтын багийн дотоод хэрэгцээнд ашиглагдах бөгөөд уг систем нь “Хяналт шалгалт”, “Өргөдөл гомдол”, “Хяналт шалгалт, өргөдөл, гомдлын тайлан, мэдээ, хайлт”, “Админ”, “Хэрэглэгчийн хяналт” гэсэн 5 үндсэн модулиас бүрдэнэ.

Хяналт шалгалт: Яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга, тэдгээрийн албан тушаалтан, улсын төсөвт үйлдвэрийн газар, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд гэсэн нэгжүүдийн үйл ажиллагаанд хийх хяналт шалгалт /гүйцэтгэл, төлөвлөгөөт, гэнэтийн, өргөдөл гомдол шийдвэрлэх/-ын удирдамж, илтгэх хуудас, танилцуулга, гарсан алдаа зөрчил, холбогдох баримт бичгийг бүх төрлийн файл хэлбэрээр оруулна.

Өргөдөл, гомдол: Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл гомдол, түүний үндэслэл, аль салбарын ямар байгууллага, албан тушаалтантай холбоотой гэх мэт дэлгэрэнгүй мэдээлэл, өргөдөл гомдлын шийдвэрлэлт, холбогдох баримт бичгийг бүх төрлийн файл хэлбэрээр оруулна.

Тайлан, мэдээ, хайлт: Хяналт шалгалт хийсэн яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга, тэдгээрийн албан тушаалтан, улсын төсөвт үйлдвэрийн газар, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд тус бүрээр, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт гэх мэт бүх төрлийн судалгаа, тайлан мэдээ гаргана.

Админ: Системийн хэрэглэгчийн эрх, системд хэрэглэгдэж байгаа нийтлэг код болон системийн аюулгүй байдал, системд хэрэглэгдэж байгаа процессын төлөв өөрчлөх, хэвийн үйл ажиллагааг хангана.

Хэрэглэгчийн хяналт: Энэ модуль нь бүртгэгдсэн мэдээллийг хянах, шаардлагатай үед сануулга өгөх, мэдээлэл давхцаж бүртгэгдсэн, ямар нэг алдаа гарсан тохиолдолд холбогдох баримтуудтай танилцаж, мэдээллийг засах, устгах боломжтой байх бөгөөд энэ нь лог файлын бүртгэлтэй байна.

ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ

Засгийн газар дахь хяналтын тухай хуульд заасны дагуу байгууллага, албан тушаалтны ямар үйл ажиллагаанд ямар үндэслэлээр хяналт шалгалт хийсэн, хяналт шалгалтын явцад ямар хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журам зөрчсөн, зөрчлийг арилгах талаар ямар арга хэмжээ авч ажилласан, өргөдөл гомдын шийдвэрлэлт гэх зэрэг дэлгэрэнгүй бүртгэл хөтлөх, Засгийн газар, Монгол Улсын Ерөнхий сайд, Монгол Улсын сайд Хяналт, үнэлгээний үндэсний хорооны даргыг бодит мэдээ мэдээллээр хангах, олон талт тайлан мэдээ гаргах, ажлын уялдаа холбоог сайжруулна.

Системийн төслийг хэрэгжүүлэх үйл явц үндсэн гурван үе шатанд хуваагдана.

I үе шат: Процессын судалгаа, шинжилгээ, системийн архитектур, загвар систем хийх

а. Ажил гүйцэтгэх хуваарьт төлөвлөгөө боловсруулан захиалагч талд танилцуулан, багийн ахлагчаар батлуулах

б. Энэ үе шатанд гүйцэтгэгч болон захиалагч талууд хамтран захиалагчаас санал болгосон шийдлийг боловсронгуй болгох, систем нэвтрүүлснээр гарах үр дүнг хэлэлцэх, системд тавигдах шаардлагыг нарийвчлан судлах, системийн агуулга, функциональ шаардлагыг эцэслэн тодорхойлох боломжийг олгоно.

с. Системийн хэрэглэгчийн шаардлагыг багтаасан системийн ерөнхий шаардлагыг эцэслэх;

д. Системийн архитектур, бүрэлдэхүүн хэсгүүд, модулиуд, мэдээллийн технологийн дэд бүтцийн талаарх шийдлүүдийг эцэслэх;

е. Хэрэглэгдэх технологи, кодчиллын сан, системийн код хөгжүүлэгчдийн баримтлах зарчмыг тодорхойлох

ф. Эцэслэн гарсан системийн шийдэлд үндэслэн хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулах (Эхлэлийн тайлан)

II үе шат: Системийн хөгжүүлэлт хийх.

III үе шат: Системийг турших, нэвтрүүлэх, засварлах, сургалт зохион байгуулах. (Эцсийн тайлан)

МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

Функциональ бус шаардлагуудыг нэгдүгээр үе шатанд хэлэлцэнэ. Дараах үндсэн шаардлага байна. Үүнд:

- Кибер аюулгүй байдал, өгөгдөл хамгаалах аргачлал, өгөгдлийг хэрхэн хадгалах, удирдах, аюулгүй байдлыг тусгасан зааварчилгаатай байх;
- Нээлттэй эхийн технологи ашиглах;
- Системд нэгэн зэрэг хандалтын дэлгэрэнгүй төлөвлөгөө гаргах;
- Дэд системүүд ажиллагааны хувьд хоорондоо үл хамааралтай байх;
- Дэд бүтцийн байршуулалт, засвар үйлчилгээ, бэлэн байдлын шаардлага хангасан байх;
- Хуульд заасан үйл ажиллагаатай холбоотой бүх процесс ажиллагааг системд загварчилж оруулах;
- Албан тушаалтны үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн системд хандах эрхийг дурын байдлаар үүсгэх мөн түүнчлэн системийн нэгж процесст хэрэглэгчийн дүр болон эрхийг тохируулах боломжтой хэрэглэгчийн удирдлагын системтэй байх;
- Процесс ажиллагаа нь хуулийн хугацаатай, мөн хуульд зааснаар сунгалт хийгддэг тул хугацаа дуусахаас тодорхой хугацааны өмнө сонордуулга,

анхааруулга ирдэг байх;

- Монгол Улсын харьяалалгүй иргэн болон хуулийн этгээдийн бүртгэлийг бүртгэж үндсэн процесст ашиглах боломжтой байх;
- Засгийн газар дахь хяналтын тухай хууль болон бусад хууль /Захиргааны ерөнхий хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Төрийн албаны тухай хууль гэх мэт/, захиргааны хэм хэмжээний актуудын ажлын процессыг загварчилж үндсэн үйл ажиллагаанд ашиглах боломжтой байх;
- Шийдвэрлэх хугацааг системийн тохиргоо хэсгээс оруулах боломжтой байх;
- Бүртгэлийн дугаарыг системээс автоматаар олгодог байх;
- Аливаа шийдвэрийг тухай бүр нь даруй бүртгэх, олон хоногоор хугацаа алдаж, нөхөж бүртгэх асуудлыг хязгаарлах;
- Өгөгдөл дутуу бүртгэгдсэн тохиолдолд дараагийн бүртгэлийг бүртгэх боломжгүй / бүртгэдэггүй/ байх;
- Оролцогчдоос хүсэлт, гомдол гаргасан тохиолдолд хүсэлт, гомдлыг цохох, хариуцсан ажилтанд сонордуулга ирэх, цахим шуудан болон мессежээр мэдэгддэг байх;
- Тайлангаас гадна хуулийн зүйл анги, хэсэг, заалт , аймаг, сум, байгууллага, ажилтны нэр, үүссэн хугацаа, шийдвэрлэсэн хугацаа зэргээр төрөл бүрийн хэрэгцээт судалгаануудыг гаргах боломжтой байх, судалгааг тоогоор гаргахаас гадна шийдвэрийн жагсаалтаар гаргах,
- Тайланг сар бүр тогтсон маягтуудын дагуу гаргаж, автоматаар хадгалан архивлах боломжтой байх;
- Өргөдөл гомдол, тогтоол шийдвэрт хамаарах бүх мэдээллийг дэд цэсээр бүртгэлээр оруулж, тухайн мэдээллээс төрөл бүрийн судалгаануудыг гаргах,
- Ажилтнуудын ажлын ачааллыг харуулах боломжтой байх;
- Архивын сангийн нэмэлт өгөгдлийн сантай байх;
- Календарьт бүх хугацаатай ажлуудаа нэгтгэн хардаг байх;
- Хэрэглэгчийн хөтчөөс үл хамаарсан байдлаар ажиллах боломжтой байх;
- Хэрэглэгчдэд, энгийн, ойлгомжтой дизайны орчин үеийн чиг хандлагад нийцсэн байх;
- Системийн дээрх үг, хэллэг нь UNICODE кодчиллол дээр ажиллана;
- Хууль, тогтоомжид заасан хугацааг хэтрүүлбэл алдааны мэдэгдэл, сануулга ирдэг байх;
- Бүртгэх цонхонд үндсэн мэдээллийн баазаас автоматаар тухайн байгууллага, аж ахуйн нэгж, иргэн бүртгэгдсэн эсэхийг өмнө нь шалгадаг байх
- Тайлан, мэдээлэл оруулах систем нь цаг хугацаанаас хамаарч дохио (алерт) өгч мэдээлдэг байх, өнгөөр ялгаж харуулдаг байх;
- Систем бүрийн хувьд аудит бүртгэл болон алдааны мэдээллийн лог бичлэгийг бүртгэх боломжтой байх;

- Өгөгдлийн сангийн их өгөгдөлтэй хүснэгтүүдийг индексжүүлсэн байх;
- Робот хандалтыг хязгаарлаж, системд нэвтрэх хэсэгт Google reCAPTCHA V3 хувилбарыг ашиглах;
- Google analytics-ыг ашиглаж, хандалтын анализ хийх боломжтой байх;
- Систем бүрийн хувьд хэрэглэгч өөрөө оролт болон гаралтыг удирдах боломжтой ухаалаг тайлангийн модулиар хангагдсан байх;
- Ашиглалтын явцад гарах бүх Error Handling хийсэн байна;
- Эцсийн хэрэглэгчдэд ойлгомжтой энгийн алдааны мэдэгдэлтэй байх;
- Программ хангамжийг хөгжүүлэхдээ олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Version Control System ашигласан байна;
- Программ хангамж хөгжүүлэх явц болон баталгаат хугацаанд захиалагч болон гүйцэтгэгч талууд хурдан шуурхай холбогдох, мэдээлэл солилцохын тул Issue Tracking Software ашиглана;
- Бүх түвшний тестийн төлөвлөгөө гаргаж түүний үр дүнг тайлагнасан байна;
- Эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө гаргасан байна;
- Интернэтийн хурд, клиент компьютерын ажиллагааны нөхцөлийг тооцоолж, шаардлагатай мэдээллийг хэрэглэгчийн дэлгэц дээр 5 секундээс, тайлан болон хүсэлтүүд боловсруулах хугацаа 60 секундээс ихгүй байх;
- Системийн эцсийн хэрэглэгч болон админы сургалтын модультай байх;
- Программын бүх түвшинд хандалтын болон гүйцэтгэлийн Log хадгалсан байх;
- Программ хангамжаас гарах бүх төрлийн тайланг MS Excel, MS Word, PDF форматаар гаргах боломжтой байх;
- Программ хангамжид ашиглагдаж буй бүх төрлийн жагсаалтын мэдээллийг MS Excel, Word, PDF гэх мэт олон форматаар гаргах боломжтой байх;
- Системийн техник ажиллагааг хянах, мэдээлэх, доголдол илрүүлэх зориулалт бүхий хяналтын системтэй байх;
- “SQL injection”, “URL injection”-ээс сэргийлсэн хамгаалалтын механизмтай байх, халдлагыг мэдээлэх модультай байх;
- Системийн модуль тус бүрд гарын авлага, зөвлөмж, заавартай байх;
- Систем нь бүх түвшинд хэрэглэгчийн гарын авлагатай байх;
- Системийн хэрэглэгчийн нууц үгийн бодлого, 2 алхамт баталгаажуулалт хийх боломжтой байх;
- Функциональ тохиргоонд өөрчлөлт оруулахад систем нь бүхэлдээ унтрааж асаахгүйгээр өөрчлөлтийг ачаалах чадвартай байх;
- Системд болж буй хэвийн болон хэвийн бус үйл ажиллагааг бичлэг болгон хадгалах, түүнийг шинжлэн үзэх боломжтой байх;
- Системийн бүх өгөгдлийг хэн хаанаас, хэзээ яаж өөрчилсөн бичлэг үлдэх;
- Хайлтын систем нь системийн мэдээллийг текст агуулгыг бүрэн индексэлж хайдаг байх;

- Системтэй холбоотой дуудлагуудыг системдээ хүсэлтээр бүртгэн авч, шийдвэрлэдэг болгох;
- Системийн хэрэглэгчийн нууц үгийн бодлого олон улсын стандартад нийцсэн байх, тоон гарын үсгийг дэмжих боломжтой байх;
- Хүлээн авсан материалыг хадгалахдаа шифрлэх болон тоон гарын үсгээр баталгаажуулах боломжтой байх;
- Ажлын урсгал удирдлагын модультай байх;
- Систем хооронд интеграци хийх боломжийг бүрдүүлсэн Service Bus технологийг дэмждэг байх;
- Систем хөгжүүлэх ажлын хүрээнд бусад шаардлагатай хөгжүүлэлтийг тухай бүр хийх;
- Системийн анализ, шинжилгээг хийж захиалагчид хүлээлгэн өгөх;
- Шинээр боловсруулах программ хангамжийн байх ёстой загварыг боловсруулан захиалагчид хүлээлгэн өгөх;
- Өгөгдлийн сангийн бүтцийн диаграм баримтжуулан хүлээлгэн өгөх;
- Хэрэглэгчийн шаардлагын өөрчлөлт баримтжуулан хүлээлгэн өгөх;
- Системийн ажиллагаа хурдан, найдвартай байх;
- Нэг хэрэглэгчийн эрхээр давхар нэвтрэх боломжгүй байх;
- Хэрэглэгчийн компьютер дээр нэмэлт тохиргоо болон программууд суулгах шаардлагагүй байх;
- Системд нэвтэрсэн хэрэглэгч ямар нэг үйлдэл хийхгүй идэвхгүй 5-8 минут болсон бол эрх нь автоматаар гардаг байх;
- Хэрэглэгчийн нууц үгийг улирал бүр автоматаар солих шаардлага тавих;
- Олон хэрэглэгч ажиллахдаа нэг хэрэглэгчийн үйлдэл өөр хэрэглэгч үйлдэл нөлөөлөхгүй байх;
- Цахимаар илгээсэн баримт бичгүүдийн файлын хэмжээ, гаргацтай байдал зэргийг нэгдсэн нэг форматад хувирган, тухайн баримт бичиг дээрх текст бүхий агуулгыг текст дүрст таних технологи ашиглан хуулбарлах, системд хадгалах боломжтой байх./гүйцэтгэгч технологийн хувилбарыг санал болгох/

ХЭРЭГЛЭГЧИЙН ИНТЕРФЕЙСИЙН ШААРДЛАГА

Гүйцэтгэгч нь олон улсын ISO 9241-210:2019 болон Web Content Accessibility Guidelines (WCAG) 2.0 стандартын дагуу боловсруулсан дэлгэцийн загварыг (өгөгдөл оруулах хүснэгт, удирдлагын dashboard, хайлтын интерфейс гэх мэт) зурж ирүүлнэ.

Хэрэглэгчийн интерфейс дараах шаардлагыг хангана:

- Интерфейсийн элементүүдийг хэрэглэгчийн дэлгэцийн хэмжээ, нягтаршилд автоматаар тохируулж харуулах,
- Систем нь хэрэглэгчийн ашиглах техник, тоног төхөөрөмжтэй (мэдрэгчтэй дэлгэцтэй, компьютерын гартай гэх мэт) автоматаар тохирдог байх,

- Хэрэглэгчийн интерфейс нь “User-centered design” зарчмын дагуу веб системүүдэд байдаг хамгийн нийтлэг, тэргүүн туршлагуудыг дизайн болон бусад шинж чанаруудад хэрэгжүүлсэн байх шаардлагатай. Систем нь бүх түвшний хэрэглэгч ажлаа гүйцэтгэхэд тохиромжтой, ойлгоход энгийн байх,

Хувилбарын төлөвлөгөө:

Системийн хөгжүүлэлтийг хэд хэдэн хувилбарт хувааж, тухайн хувилбарт ямар, ямар хэрэглэгчийн шаардлага байх, хөгжүүлэх, нэвтрүүлэх, төлөвлөгөөг гүйцэтгэгч тал гаргасан байна.

Төслийн баримтжуулалт:

Системийн баримт бичиг, системийн диаграм, архитектур, туршилт, эх кодыг хэрхэн баримтжуулах талаар тодорхой тусгасан тайланг төслийн гарааны үе шатанд (гарааны тайланд) захиалагчид хүлээлгэн өгч танилцуулна.

Системийн чанарын удирдлага:

Системийн чанарыг баталгаажуулахын тулд системийг хөгжүүлж эхлэхээс нэвтрүүлэх хүртэл явцад туршилт, чанарын баталгаажуулалт хийгдэх шаардлагатай. Гүйцэтгэгч нь чанарын баталгаажуулалт, туршилтын ажилд тусгайлан зориулсан хүний болон бусад нөөцийг гаргах ёстой бөгөөд дараах тайлангуудыг захиалагчид өгнө:

Үйл ажиллагаа	Зорилго	Тайлан	Давтамж
Автоматжуулсан туршилт	Шинэ орсон кодын өөрчлөлт өмнө ажиллаж байсан функц, үйлдлийг эвдэж байгаа эсэхийг шалгах	Автоматжуулсан туршилтын тайлан (unit test coverage, module tests, UI tests etc.)	Спринт болгоны дараа
Код хянах (Code review)	Хэн нэгэн хөгжүүлэгчийн бичсэн код системийн архитектур, дизайнд таарч байгаа эсэх, мөн системд алдаа үүсгэх эрсдэл байгаа эсэхийг нөгөө хөгжүүлэгч нь харж шалгах	Код хянах тайлан (Хэн хэний эрсдэлтэй кодоод хяналт хийж ямар алдаа олж, яаж засварласан тухай байна)	Спринт болгоны дараа
Систем тест хийх (System test)	Хувилбарт хөгжүүлсэн бүх хэрэглэгчийн шаардлагыг шаардлага хангасан эсэхийг гүйцэтгэгч талаас шалгах	Систем тест тайлан (System test report)	Хувилбар болгоны төгсгөлд
Хэрэглэгч тест хийх (User acceptance test)	Хувилбарт хөгжүүлсэн бүх хэрэглэгчийн шаардлагыг (ажлын даалгаврын дагуу) шаардлага хангасан эсэхийг захиалагч талтай хамтран шалгах	Хэрэглэгчийн тестийн тайлан (User acceptance test report)	Хувилбар болгоны төгсгөлд
Stress test	Системийн ачаалал даах чадварыг шалгах	Stress test report	Хувилбар болгоны төгсгөлд

ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН

Энэ мэдээллийн сан үүсгэн, шинэ системтэй болсноор дараах үр дүн гарна гэж тооцоолж байна. Үүнд:

1. Хяналт шалгалтын удирдамж болон хяналт шалгалт хийсэн бүрэлдэхүүний талаар дэлгэрэнгүй мэдээллийг хөтлөх, судалгаа, тайлан мэдээ гаргах боломжтой болно.

2. Хяналт шалгалт хийсэн яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга, тэдгээрийн албан тушаалтан, улсын төсөвт үйлдвэрийн газар, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд тус бүрд хяналт тавих, судалгаа, тайлан мэдээ гаргах боломжтой болно.

3. Хяналт шалгалт хийсэн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа, мөн хяналт шалгалт хийсэн үндэслэл бүрээр төрөлжүүлэн хөтлөх, хянах, судалгаа, тайлан мэдээ гаргах боломжтой болно.

4. Хяналт шалгалт, өргөдөл, гомдлын хүрээнд илэрсэн алдаа, зөрчил, ямар хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журам зөрчсөн асуудлыг хянах, судалгаа, тайлан мэдээ гаргах боломжтой болно.

5. Тайлан, танилцуулга, хяналт шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, шийдвэрлэлтийн байдал, албан шаардлага, мэдэгдэл зэргийг хөтлөх, үйл ажиллагаанд ашиглах, судалгаа, тайлан мэдээ гаргах боломжтой болно.

6. Дээрх үйл ажиллагаатай холбоотой цуглуулсан бүх төрлийн баримт бичгийг цахим мэдээллийн санд хадгалах, ашиглах боломжтой болно.

7. Хяналт шалгалттай холбоотой төрөл бүрийн үзүүлэлтээр хайлт хийх, статистик мэдээ гаргах боломжтой болно.

ЗӨВЛӨХӨД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Зөвлөх нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1.1. Улсын бүртгэлийн байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд байх.

1.2. 3-аас дээш төсөлд, тэр дотроо төрийн байгууллагыг систем хөгжүүлэлтийн явцын болон гүйцэтгэлд хяналт тавих, зөвлөгөө, удирдамжаар хангаж байсан туршлагатай бол давуу тал болно.

№	Албан тушаал	Ажилтны тоо	Ажилласан жилийн туршлага	Мэргэжил
1	Төслийн удирдагч	1	10 жил	Бизнесийн удирдлага, Компьютерийн ухаан, Программ хангамжийн мэргэжлийн аль нэг нь
2	Системийн шинжээч	1	5 жил	Программ хангамж, Мэдээллийн системийн аль нэг нь
3	Өгөгдлийн сангийн инженер	1	5 жил	Өгөгдлийн сангийн загварчлал, удирдлага
4	Программ хангамжийн	1	5 жил	Программ хангамж

	инженер			
5	Кибер аюулгүй байдлын инженер	1	5 жил	Программ хангамж, Кибер аюулгүй байдлын мэргэжлийн аль нэг нь

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА

Уг Ажлын даалгаварт тусгасан ажлыг 2 сарын хугацаанд хийж гүйцэтгүүлэхээр төлөвлөж байна.

САНХҮҮЖИЛТ

Улсын төсвийн хөрөнгөөр: Гэрээний нийт үнийн дүн 80.000.000 төгрөгөөс хэтрэхгүй байна.

ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

Төлбөрийг гэрээт ажлын нэгдүгээр үе шат дуусгаж, эхлэлийн тайланг ажил хүлээж авах ажлын хэсэгт хүлээлгэн өгсөний дараа санхүүжилтийг бүрэн олгоно.

БАТАЛГААТ ХУГАЦАА

Баталгаат хугацаа нь гүйцэтгэгчтэй байгуулсан үндсэн гэрээний хугацаа дууссанаас хойш 12 сар байна. Энэ хугацаанд гүйцэтгэгч нь хөгжүүлэлтийн үе шатанд оруулсан бүх сервис болон бусад нэмэлт сайжруулалт хийх зэрэг ашиглалтын үйлчилгээ үзүүлнэ. Энэ хугацаанд системийн нийт гүйцэтгэлийн 30%-д нэмэлт засвар өөрчлөлтийг хийж болно.

Системийн 1 жилийн баталгаат хугацаа дууссаны дараа захиалагч гүйцэтгэгчтэй үндсэн гэрээний тодорхой хувиар засвар үйлчилгээний гэрээг байгуулан ажиллаж болно.

ТАЙЛАН, ҮР ДҮН

Зөвлөх нь цахим систем, оюуны өмчийн эрх, админ эрх болон ажлын тайлангаа цаасан, цахим хэлбэрээр дараах байдлаар бэлтгэж өгнө. Үүнд:

- Эхлэлийн тайлан: Ажил эхэлснээс хойш 7 хоногийн дотор монгол хэлээр өнөөгийн нөхцөл байдлын шинжилгээ, ажлын дэлгэрэнгүй төлөвлөгөө, хүрэх үр дүнг тодорхойлж боловсруулан гаргаж өгнө.
- Явцын тайлан: Ажил эхэлснээс хойш 20 хоногийн дотор гол хүрсэн үр дүн, хийгдсэн ажлын тайлан, ажлын даалгаврын төслөө гаргаж өгнө.
- Гүйцэтгэлийн тайлан: цахим систем хөгжүүлэлтийн явцад сар тутам систем хөгжүүлэлтийн ажил Ажлын даалгаварын дагуу явагдаж байгаа эсэх тайланг гаргаж өгнө.
- Хүлээн авах эцсийн тайлан: Цахим систем хүлээн авах үед систем хөгжүүлэлтийг бүрэн дууссан эсэх, хүлээн авах боломжтой эсэх тайланг гаргаж өгнө.

ХЯНАСАН: АХЛАХ ХЯНАН
ШАЛГАГЧИЙНАЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.УНДРАА

БОЛОВСРУУЛСАН: ХЯНАН ШАЛГАГЧ
РЕФЕРЕНТ



Ц.БАТТУЛГА

БОЛОВСРУУЛСАН: ХЯНАН ШАЛГАГЧ
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Б.ЭРДЭНЭБАЯР